



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,  
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,  
И-мэйл: mofa@mofa.gov.mn; Вэбсайт: www.mofa.gov.mn


2022.04.15 № 01/1310

танай 2022.03.31-ны № 10 -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Н.ЭНХБОЛД ТАНАА

Таны 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 10  
тоот албан бичгээр ирүүлсэн асуулгын хариуг  
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт .....<sup>5</sup> хуудастай.



З.МЭНДСАЙХАН

00000851

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
Хүнс, хөдөө аж ахуй,  
хөнгөн үйлдвэрийн Сайдын  
2022 оны 04 дүгээр сарын 15-ны  
өдрийн 01/310 дугаар албан  
бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Н.ЭНХБОЛДЫН АСУУЛГЫН ХАРИУ

**Нэг.Сүүний урамшууллын журмын хэрэгжилтийн явц, үр дүн,  
шүүмжлэлд туссан асуудлын тайлбар:**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Хүнсний тухай хуулийн 8.3, 8.5 дахь заалтыг тус тус үндэслэн “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлуулан 2 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Журамд шаардлага хангасан сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү тушаасан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшууллыг тухайн оны 11 дүгээр сарын 1-нээс дараа оны 3 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд 1 литр тутамд таван зуун төгрөгөөр тооцож олгохоор заасан.

Малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид төрөөс урамшуулал олгоход тавигдах дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд урамшуулалд хамрагдахаар журамласан. Үүнд:

1. Үндэсний статистикийн хорооны тухайн жилийн мал тооллогын “А” дансны мэдээлэлд бүртгэгдсэн байх;
2. Мал эмнэлгийн гэрчилгээ авсан байх;
3. Борлуулалтыг татварын е-баримтаар бүртгэгдэн баталгаажсан байх;

Уг журмын дагуу шаардлага хангасан сүү боловсруулах 8-12 үйлдвэрт 2020-2021 оны сүүний урамшуулалд 4,2 тэрбум төгрөг, 2021-2022 онд 5,3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна. Доорх хүснэгтэд түүхий сүүний нийлүүлэлтийн хэмжээ, урамшуулалд хамрагдсан малчин, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тоог харуулав.

Хүснэгт 1.

	Нийлүүлсэн түүхий сүүний хэмжээ /литр/	Хамрагдсан малчдын тоо	Зарцуулсан мөнгөн дүн ₮
2020-2021 онд	8,585,965	9516	4,292,982,500.0
2021-2022 онд	10,595,689	8851	5,297,844,500.0

/Эх сурвалж ХХААХҮЯ/

2021-2022 оны бэлтгэн нийлүүлэгчдээс нийлүүлсэн түүхий сүүний хэмжээг 2021-2022 онд нийлүүлсэн түүхий сүүний хэмжээтэй харьцуулахад 23.2 хувиар өссөн байна.

Иймд сэрүүний улиралд сүүний урамшуулал олгосноор малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжих замаар өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийг

нэмэгдүүлэх, хүн амын ундны сүүний хэрэгцээг тогтвортой, хүртээмжтэй хангах үндсэн нөхцөл дунд болон урт хугацаанд бүрдэж байгаа юм.

Улсын Их хурлын гишүүн Ц.Энхболд таньд хандсан өргөдөлд дурдагдсан Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг 4-р багийн мал бүхий иргэд 2021 оны 12 дугаар сарын урамшууллаас хасагдсан бөгөөд нөхөн олгох эрх зүйн үндэслэлгүй юм. Эдгээр нэр бүхий 25 малчдын мэдээллийг судлан үзэхэд:

1.Н.Эрдэнэчулуун, А.Батнасан, Ц.Хуяг, А.Мөнхбаяр, Д.Цэрэнбатаа, Ч.Энхтайван, Д.Батсайхан, С.Жаргалсайхан, Х.Хишигням, Д.Баясгалан, Д.Давааням, Н.Бат-Эрдэнэ, Х.Цогтбаатар, А.Болдбаяр, Р.Эрдэнэбаатар, Б.Болормаа, Д.Батбаяр, Т.Намжим О.Отгонбаатар нарын малчид 2021 оны 12-р саруудад мал эмнэлгийн гэрчилгээ аваагүй байна.

2.Т.Цэрэнтогтох, Х.Сэржмядаг нарын малчид 2021 оны Үндэсний статистикийн хорооны мал тооллогын "А" дансны мэдээлэлд бүртгэгдээгүй байна.

3. Р.Шинэбаатар малчин татварын е-баримтаар бүртгэгдэн баталгаажаагүй байна.


4.Б.Жаргалсайхан, О.Нацагдорж, Г.Галхүү нарын малчид 2021 оны 12-р сарын урамшуулал авсан байна.

Цаашид урамшууллаас хасагдсан малчин Үндэсний статистикийн хорооны мал тооллогын "А" дансны мэдээллийн бүртгэлд хамрагдаж, мал эмнэлгийн гэрчилгээ болон татварын цахим е-баримтын системд бүртгүүлж, сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлж урамшуулалд хамрагдах боломж нь нээлттэй юм.

**Хоёр. Дотоодын сүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн хэмжээ, хуурай сүүний импортын талаар:**

Монгол Улсын хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүний 206 үйлдвэр, цех үүнээс тогтмол үйл ажиллагаа явуулдаг 36 үйлдвэр, цех 77 хөргөлтийн төв үйл ажиллагаа явуулж, тэдгээрт нийт 1560 гаруй хүн ажиллаж байна. Сүүний боловсруулах салбарын суурилагдсан хүчин чадал жилд 400.0 мян.тн бөгөөд өнөөдрийн байдлаар 51 хувийг ашиглаж байна.

2021\* оны урьдчилсан гүйцэтгэлээр үйлдвэрийн аргаар 205.4 сая.литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулсан бөгөөд өмнөх оны тоо хэмжээтэй харьцуулахад 16.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүн амын сүүн бүтээгдэхүүний хэрэглээний хангамжийн төвшинг нэмэгдүүлэхэд улирлын хамаарал ихээхэн нөлөөлж байна. Эрчимжсэн мал аж

ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ нийт нийлүүлэлтийн 85 хувийг бүрдүүлж байгаа хэдий ч өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын ундны сүүний хэрэгцээг бүрэн хангах нөхцөл, боломж бүрдэхгүй байна.

Иймд дотоодын аж ахуйн нэгжүүд хуурай сүүг импортлон үйлдвэрлэлдээ ашиглаж байна. Тухайлбал импортын хуурай сүүний 55 хувийг шингэн сүүний үйлдвэрлэлд, 40 хувийг сүүн бүтээгдэхүүн /зайрмаг, тараг/-ний үйлдвэрлэлд 5 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тус тус хэрэглэж байна.

Импортолсон шингэн болон хуурай сүүний тоо хэмжээ, /тн/

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Шингэн сүү	192	197	0	0	0.1	0	0	0
Хуурай сүү	3473	3138	2552	3740	4193	5500	4801	5450

/Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар/

**Гурав. Сум орон нутаг дахь мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж, үйлчилгээний төлбөрийн талаар:**

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хууль соёрхон батлагдаж, 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бие даасан бүтэц, үйл ажиллагаатай Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болон зохион байгуулагдсан.

“Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалтын дагуу “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь улсын хэмжээнд мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэж байна.

Мал эмнэлгийн ерөнхий газар, харьяа аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газруудад 400, сум, дүүргийн мал эмнэлгийн тасагт 674, мал эмнэлгийн хяналтын цэгт 60 нийт 1134 малын эмч, төрийн албан хаагчаар ажиллаж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 1133 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид /хувийн хэвшилд/ малын их эмч 816, малын бага эмч 581, мал зүйч 126, нийт 1523 мал эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг тооцож үзэхэд нэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 74.2 мянга, нэг малын эмчид 48.2 мянган мал оногдож байгаа нь олон улсын дунджаас 5 дахин өндөр үзүүлэлттэй байна.

Сум, дүүрэг дэх Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх мал эмнэлгийн арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газрын бодлого, төлөвлөлтийн хүрээнд батлагдсан стандарт, техникийн зохицуулалт, журам, зааврын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30.2 дахь зүйлд заасны дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд үйлчилгээний хүрээнээс хамааран ерөнхий болон төрөлжсөн, тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний чиглэлээр “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандарт”-ын дагуу үйл ажиллагаа эрхэлж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 1133 мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нэгж ажиллаж байгаагаас үйлчилгээний төрлөөр ангилан үзвэл:

- ✓ Мал эмнэлгийн ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний нэгж-940
- ✓ Мал эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний нэгж-120
- ✓ Мал эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний нэгж-73

**Мал эмнэлгийн үйлчилгээний үйлчилгээний төлбөрийн талаар:**

“Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэх хэсэгт “нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, үйлчилгээний хөлсний норматив батлах, малын өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эм, бэлдмэлийн нөөц бий болгох, энэ хуульд заасан болон бусад зардлыг баталж, хэрэгжилт, зарцуулалтад нь хяналт тавих” гэж зааснаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, мөрдөж байсан нь хүчингүй болсон.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 33 дугаар 33.1.2.3-т заасны дагуу Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 118, А/201 тоот хамтарсан тушаалаар “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив”-ыг баталсан.

Энэ зохицуулалтаар улсын төсвөөр гүйцэтгэх буюу гоц халдварт өвчний үед малд эмнэл зүйн үзлэг хийх, тарилга хийх, халдваргүйтгэл хийх, лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авах, дуудлага үйлчилгээний үнийн тарифыг тогтоож, 2022 оноос эхлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Улсын төсвөөс санхүүжигддэггүй бусад мал эмнэлгийн үйлчилгээний үнэ тариф одоогоор хуулийн зохицуулалтгүй, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, мэдлэг, ур чадвар, үйлчилгээний соёл зэргээс шалтгаалан зах зээлийн өрсөлдөөний зарчмаар явагдаж байна.

**Дөрөв.Сумын гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн чадамж, өнөөгийн нөхцөл байдал болон цаашид чадваржуулах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар:**

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл бүхий малын эмчтэй, стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмжтэй, мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд байх эрх зүйн зохицуулалттай юм.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30.1 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа” MNS5368:2018 стандартын шаардлагын хүрээнд ерөнхий болон тусгай, төрөлжсөн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 528 асуулгыг боловсруулан мал эмнэлгийн нэгдсэн системд байршуулж, 989 нэгжийг хамруулан стандартын үзлэгийг явуулан, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн чадавхыг үнэлгээ хийхэд:

- ✓ Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нь ихэвчлэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх 1 малын эмч мэргэжилтэнтэй бөгөөд 1 малын эмчид ногдох малын тоо их;
- ✓ Малын эмчийн насжилтийн хувь өндөр, нийт малын эмчийн 50-иас дээш хувь нь хөдөлмөрийн наснаас давсан;
- ✓ Мэргэшсэн туслах ажилтны хүний нөөц дутмаг, ихэнх нэгжид байнгын тогтвортой ажиллах туслах ажилтан байдаггүй, тухайн мал эмнэлгийн

арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслах ажилтанг түр авч ажиллуулах;

- ✓ Мал эмнэлгийн байртай боловч стандартын шаардлагад хангадаггүй;
- ✓ Дуудлагын үйлчилгээнд тээврийн хэрэгсэл, үзлэг эмчилгээний тоног төхөөрөмжийн хүрэлцээ, хангалт сайн боловч хүйтэн хэлхээний суурин болон зөөврийн халдваргүйтгэл хийх тоног төхөөрөмж, бэлдмэлийн нөөц хангагдаагүй гэсэн дүгнэлт гарсан.

Цаашид мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг чадваржуулахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- ✓ Орон нутагт ажиллах малын эмчийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- ✓ МЭҮН үүсгэн байгуулахад тохиромжтой нөхцөл бүрдүүлэх,
- ✓ МЭҮН-ийн стандартад өөрчлөлт оруулах,
- ✓ Нэг үйлчилгээний нэгж 50,0 мян.толгой малд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх,
- ✓ Залуу малын эмчийг МЭҮН эрхлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх,
- ✓ Малчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг хийх.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам